



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2016

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ МОНГОЛД



## **Жилийн тайлан 2016**

### **Швейцарийн хөгжлийн агентлаг**

#### **Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар**

Скай Плаза бизнес төв  
Элчингийн гудамж, 1-р хороо  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар  
Монгол Улс

Ш/х 37  
Улаанбаатар 14210  
Монгол улс

Утас: 976 11 331422  
Факс: 976 11 331420  
Э-шуудан: ulaanbaatar@eda.admin.ch

Вэб: [www.eda.admin.ch/mongolia](http://www.eda.admin.ch/mongolia)

#### **Гэрэл зураг & Эх бэлтгэл**

Швейцарийн хөгжлийн агентлаг  
Интерпресс ХХК

Зураг © Швейцарийн хөгжлийн агентлаг/Д.Давааням  
2005 онд Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын малчдын  
хүсэлтээр 1000 га хадлангийн талбайг чулуугаар  
хашихад нь ШХА-ийн Ногоон алт төслийн зүгээс  
дэмжлэг үзүүлсэн. Түүнээс хойш тус сумын 560 малчин  
өрх жил бүр 3000 гаруй тонн хадлан бэлтгэснээр  
өвөлжилтийн бэлтгэлээ сайтар базааж байна.

#### **Хэвлэлт**

Интерпресс ХХК

© SDC 2017



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2016

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ МОНГОЛД

## Агуулга

Оршил	4
2016 оны онцлох үр дүн	6
■ Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал	7
■ Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС)	13
■ Төрийн захиргааны шинэтгэл, нутгийн удирдлага ба иргэдийн оролцоо	19
■ Тогтвортой бичил уурхай төсөл	25
2017 оны хэтийн төлөв	29
Товчилсон үгсийн жагсаалт	30

# Оршил

2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд төр засгийн бүтцэд ихээхэн өөрчлөлт гарлаа. Харин бодлогын томоохон өөрчлөлт хараахан гарсангүй. ШХА-ийн үйл ажиллагааны стратеги ч шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй ерөнхийдөө нийцэж байна. 2016 онд “Монгол улсын Тогтвортой хөгжлийн алсын хараа 2030”, “2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” гэсэн хоёр чухал бодлогын баримт бичгийг баталлаа. Эдгээр нь шинээр гарсан 2030 оны Тогтвортой хөгжлийн асуудлууд, Тогтвортой хөгжлийн зорилтуудад тулгуурласнаар Монгол улс 2030 оны зорилтуудыг өөрийн болгож нутагшуулсан анхны улсын нэг болсон юм.

Эдийн засгийн уналт төсөөлж байснаас ч илүү даамжирч төсвийн алдагдал тэллээ. Монгол улсыг дундаас дээш орлоготой орны түвшнээс дундаас доош орлоготой орны түвшинд шилжүүлэв. Оюу Толгойн уурхайн хөрөнгө оруулалтын үр дүнд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэнэ гэсэн хүлээлт хараахан биелсэнгүй. Олон улсын валютын сан Монгол Улсын Засгийн газарт тусламж үзүүлэхэд бэлэн байгаа бөгөөд талууд хэлэлцээр хийсээр байна.

Эдийн засгийн хямрал ядууст хүндээр тусч нийгмийн тэгш бус байдал улам хурцдах эрсдэлтэй тулгарлаа. Ажилгүйдэл нэмэгдэж, орлого буурсны уршгаар гэр бүлийн хүчирхийлэл ихсэх, хөдөө орон нутагт гар

аргаар хувиараа ашигт малтмал олборлогчид олноор бий болох талтай. Нийгмийн салбарын төсвийн санхүүжилт хүндэрч нийгмийн үйлчилгээг сайжруулахад бэрхшээлтэй болж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) төсөв ч ихээхэн танагдаж болзошгүй. Ядуурлыг бууруулах, жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих асуудал ч урьд өмнөхөөс илүү анхаарал татахын хамт эдийн засгийг олон төрөлжүүлэх, ялангуяа хөдөөгийн хүн ам, малчид, тариланчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх чиглэлээр ШХА-аас оруулж буй хувь нэмэр улам бүр ач холбогдолтой байх болно.

Хотжих үйл явц, төрийн үйлчилгээний хүртээмжийн асуудал томоохон сорилт хэвээр байна. Хот суурин газрууд, ялангуяа Улаанбаатар хотын агаарын чанарын түвшин ДЭМБ-ын стандартаас хамаагүй өндөр (100 гаруй дахин) байгаа нь хүн амын эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ чиглэлд хараахан санхүүжилт гаргаагүй, олон нийтийн мэдлэг мэдээлэл хэтэрхий бага байгаагаас дорвитой ахиц дэвшил гарсангүй.

Олон улсын харилцааны хувьд Монгол улс 2016 онд АСЕМ-ын 11 дүгээр дээд хэмжээний чуулга уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Энэ нь тус улсын хувьд олон улсын хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, Монгол улсад ашигтай хоёр талын гэрээнүүд байгуулах томоохон боломж байлаа.




АСЕМ-ын 11-р дээд хэмжээний чуулга уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж ШХУ-ын Ерөнхийлөгч Иохан-Амманн Шнайдерыг хүлээн авч уулзжээ.  
© Монголын Гэрэл зурагчдын нэгдсэн холбоо 2016

### Монгол дахь Швейцарийн хөгжлийн хамтын ажиллагаа

“ШХА-ийн 2013-2017 оны хамтын ажиллагааны стратеги” хэрэгжээд сүүлийн жилдээ орж байна. Швейцарийн хамтын ажиллагааны стратегийн 2013-2016 оны зорилт бол Монгол улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм. ШХА энэ зорилтод хүрэхийн тулд харилцан хамаарал бүхий дараах гурван тэргүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна:

- Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал;
- Мэргэжлийн боловсрол, сургалт;
- Засаг захиргааны шинэтгэл, нутгийн удирдлага, иргэдийн оролцоо.



# 2016 оны онцлох үр дүн



## Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал (ХААХАБ):

Өнгөрсөн онд дөрвөн аймгийг шинээр хамруулснаар “Бэлчээрийн тогтвортой менежментийн төсөл” нийт 11 аймагт хэрэгжиж байна. Энэ хүрээнд 19,000 гаруй малчин өрхөд нийт 2 тэрбум гаруй төгрөгийн жижиг зээл олгожээ. Малчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зах зээл дээрх борлуулалт өссөнөөр орлого нь нэмэгдлээ. Шинээр эхэлсэн Хүнсний ногооны төсөл ч хүнсний ногооны шинэ сортуудыг нутагшуулж, үрийн үйлдвэрлэлийг хоёр дахин нэмэгдүүлсэн гэх зэргээр үр дүнгээ хэдийн өгч эхэлжээ.



## Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС):

Төсөл хэрэгжүүлж буй зорилтот бүс нутаг дахь мэргэжлийн боловсролын сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин дээшиллээ. Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үр дүнтэй болох нь нотлогдов. Амьдрах ухааны хичээлүүд институтжиж, залууст ээлтэй эмнэлгийн үйлчилгээг хүртэгсдийн сэтгэл ханамжийн түвшин маш өндөр байна. Дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулах тогтвортой хөгжлийн төлөөх боловсролд тулгуурласан шинэчлэлүүд батлагдаж, бүх сургуулиудад хэрэгжиж эхэллээ.



## Засаг захиргааны шинэтгэл, нутгийн удирдлага, иргэдийн оролцоо (Засаглал):

Төрийн үйлчилгээний хүртээмж, орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаа сайжирсаар байна. Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдсээр байгаа. Засгийн газар төвлөрлийг сааруулах бодлогыг баталж, шууд ардчиллын хэрэгслүүдийн тухай хуулийн төслийг өргөн барихад бэлэн боллоо. Засаглалын чиглэлээр гаргасан ололт амжилтуудыг нэгтгэх, ялангуяа Монгол улсын эдийн засгийн хямрал, ардчиллын өсөлт хөгжилтэй уялдуулж харах хэрэгтэй байна.



## Бичил уурхайн чиглэлээр:

Хувиараа ашигт малтмал олборлох ажиллагааг зохион байгуулан албажуулах ажлын үр шимийг бичил уурхайчид хүртэж, бичил уурхай эрхлэх газрын зөвшөөрөл нэмэгдээд зогсохгүй хөдөлмөр хамгааллаа сайруулж, орлого нь нэмэгдэж байна. Ингэснээр эмх замбараагүй бөөгнөрөл, хошуурлыг багасгах боломжтой боллоо. Нөхөн сэргээлтийн өөрийн гэсэн аргачлалтай болсон бичил уурхайчид одоо ашигласан газраа хамгаалж, нөхөн сэргээж байна.



Хөдөө аж ахуй, хүнсний  
аюулгүй байдал

# Хөтөлбөрийн онцлох үр дүн

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт Швейцарийн хөгжлийн агентлаг нь хүнсний аюулгүй байдалд голлон анхаарах замаар хөдөө аж ахуйн бүтээмжийг дээшлүүлж, улмаар хөдөө орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж, малчин өрхийн тогтвортой амьжиргаанд дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

## **Бэлчээрийн удирдлагыг сайжруулах нь**

Бэлчээрийн доройтол, талхагдлыг бууруулах хамтын менежментийг хөхиүлэн дэмжих зорилгоор малчид Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийн нэгдсэн зохион байгуулалтад ороход нь ШХА дэмжлэг үзүүлж ирсэн. Одоогийн байдлаар 35,000 орчим малчин өрх 1300 БАХ-т нэгдэн, улмаар сумдын БАХ-үүдийн холбоо болон Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоог байгуулсан. БАХ-үүд орон нутгийн захиргаатайгаа албан ёсны гэрээ байгуулан бэлчээрийн удирдлагыг сайжруулахаар ажиллаж байна.

Бэлчээрийн удирдлагын энэхүү амжилттай хэрэгжиж буй санаачлагыг орон нутгийн болон төр засгийн эрх баригч байгууллагууд хүлээн зөвшөөрч бодлогын түвшинд гаргаж тавьсан (Бэлчээрийн тухай хууль) төдийгүй орон нутагт нийт 700 бэлчээр ашиглалтын гэрээг байгуулаад

зарим аймагт хамтран санхүүжүүлж эхэллээ. 2016 онд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахыг үргэлжлүүлэн дэмжиж, дөрвөн аймагт нэмж нэвтрүүлснээр Монгол улсын нийт 21 аймгийн 11 аймгийг хамарч, улсын хэмжээний нийт бэлчээрийн 40 хувийг хамрууллаа .

Малчдын бүлгийн ахлагч нарын орон нутгийн улс төр дэх оролцоо нэмэгдсэн. 2016 оны сонгуулиар БАХ-ийн 97 тэргүүн, 217 малчин орон нутгийн иргэдийн хуралд сонгогдсон нь 2012 оны сонгуулийн үр дүнгээс 19 суудлаар илүү байна. БАХ-үүдийг хүлээн зөвшөөрөх, төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь нэмэгдсээр байгаа. Бэлчээрийн тухай хуулийн төсөлд зааснаар, мөн жендэрийн тэгш байдлыг хангах үүднээс бэлчээр ашиглалтын гэрээнд малчин өрхийн эхнэр, нөхөр хоёулаа гарын үсэг зурах юм.



Малчид бэлчээрийн хил заагийг тогтоож, сумын удирдлагатайгаа бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж байна.

© ШХА Баян-Өлгийн аймгийн Буянт сум



### Малчдын өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх эдийн засгийн хөшүүрэг

ШХА-ийн Ногоон алт төсөл малчдын санхүүгийн тогтвортой байдал, сайн дураар зохион байгуулалтад орох явдлыг дэмжин дундын сангийн схем нэвтрүүлж, сангийн хөрөнгийн тал хувийг малчдын хөрөнгөөр бүрдүүлэв. Эдүгээ улсын хэмжээнд 600 орчим дундын сан ажиллаж 19,000 малчин өрхөд нийт 2 тэрбум гаруй төгрөгийн жижиг зээл олгоод байна. Энэ нь малчдын хувьд эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл болон банкнаас зээл авахад хэцүү үед мөнгөтэй болох хамгийн түгээмэл арга зам болжээ.

Жижиг зээлийн энэ системийг цаашид тогтвортой ажиллагаатай, албан ёсны болгох үүднээс БАХ-дийн холбоодын зүгээс дундын сангаа хадгаламж, зээлийн хоршоо болгох санал санаачлага гаргаж байгаа төдийгүй 2016 онд анхны дөрвөн хадгаламж, зээлийн хоршоо байгуулагдаад байна.

### Малчид, тариаланчдыг зах зээлд холбох хоршоод

Ногоон алт, Монгол ногоо зэрэг төсөл малчид, тариаланчдын хамтарсан хоршоодыг зах зээлтэй холбож, бүтээгдэхүүнээ илүү өндөр үнээр борлуулах боломжийг олголоо. Тэднийг өөр хооронд нь болон холбогдох талуудтай холбох, сургалт зөвлөгөө өгөх зэрэг дэмжлэг үзүүлж байна.

2016 оны байдлаар БАХ-дэд тулгуурласан 70 хоршоо ажиллаж байгаа бөгөөд бүгд түүхий эд (хөөвөр, ноос, арьс, нэхий, мах) боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан ажиллаж, гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлж байна. Нийт 7000 малчин өрх тэдгээр хоршоодод түүхий эд бэлтгэн нийлүүлж байгаа бөгөөд энэ тоо өнгөрсөн оныхоос даруй нэг мянгаар нэмэгдсэн. Малчин өрхүүдийн жилийн орлого 2013 оны суурь үзүүлэлт болох 4.7 сая төгрөгөөс 32 хувиар нэмэгдэж 2016 онд 6.2 сая төгрөг болсон үр дүнтэй байна.

Хоршоод, боловсруулах үйлдвэрүүд нягт хамтран ажилласны үр дүнд 2015 онд 110 тонн байсан сарлагийн хөөвөр, тэмээний ноосны борлуулалтын хэмжээ 2016 онд 170 тонн болж нэмэгдлээ. Борлуулсан сарлагийн хөөврийн хэмжээ 2015 онд 44 тонн байснаас 2016 онд 49 тонн болов. Ангилан ялгалтын чанарыг



дээшлүүлсний үр дүнд сарлагийн ангилсан хөөврийн үнийг 10 хувь өсгөлөө. Дотоодын үйлдвэрлэгч нарын торомны ноос авах эрэлт нэмэгдэж 2015 онд 1.2 тонн ноос авч байснаа 2016 онд 25 тонн гаруй торомны ноосны захиалга авсан нь 2015 оноос зах зээлд нэвтрүүлсэн энэ төрлийн шинэлэг бүтээгдэхүүнийг илүү их сонирхох болсныг илтгэж байна .

Сарлагийн хөөвөр, тэмээний ноос боловсруулдаг долоон үйлдвэрийг “Берлиний загварын долоо хоног” үзэсгэлэн худалдаанд оролцоход дэмжлэг үзүүлснээр 70,000 еврогийн захиалга авчээ. Химийн бодисгүй нэхмэл бүтээгдэхүүнд олгодог Швейцарьт төвтэй ОЕКОТЕХ шошгийг танилцуулж, энэхүү гэрчилгээг авах шалгуурт боловсруулах таван үйлдвэр орохоор тохирсон байна.

#### **Малын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр**

Мал эмнэлгийн салбарт бруцеллез, шүлхий өвчний хяналтын үндэсний стратегийг боловсруулж хэрэгжүүлсэн бөгөөд малын эрүүл мэндийг хамгаалах системийн халдварт өвчин дэгдэхэд хариу үйлдэл үзүүлэх чадварыг сайжруулж байна. ШХА-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан малын эрүүл мэнд, бэлчээрийн тухай хуулийн төслүүдийг шинэ засгийн газар мөрийн хөтөлбөрийнхөө тэргүүлэх чиглэлд орууллаа.

#### **Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр**

“Монгол улсын хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулж, төмсний үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломж олгосон Швейцарийн хамгийн үр дүнтэй төслийн нэг гэж Монгол төмс” хөтөлбөрийг өндрөөр үнэлдэг.

ШХА-ийн Монгол төмс хөтөлбөрийн үр дүнд бий болсон дотооддоо төмсний үр үржүүлэх ажил тус агентлагийн дэмжлэггүйгээр 2016 онд үргэлжиллээ. 2015 оны зун гантай байсан хэдий ч Монгол төмс хөтөлбөрөөс эрт боловсордог сортын үр нэвтрүүлсний ачаар төмсний ургац бага зэрэг нэмэгдэж нэг га-гаас 12.8 тонн ургац (2014 онд га-гаас 12.2 тонн) авсан байна.

Төсөл хэрэгжих хугацаанд нэлээдгүй дэмжлэг авсан Газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Элит үр ХХК-ний хооронд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж төмсний үр үржүүлэх системийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулж байна.

#### **Хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж ядуурлыг бууруулах нь**

ШХА хөдөө аж ахуйн салбарын төслүүдээрээ дамжуулж малчид, тариаланчдын бүтээмжийг дээшлүүлэх, улмаар тэдний орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг илүү баталгаажуулахыг эрмэлзэж байна.

2016 оноос хэрэгжиж эхэлсэн Хүнсний ногоо төсөл хэдхэн сарын дотор үр дүнгээ өгч шинэ сортын нутагшуулсан үрийг нэвтрүүлээд зогсохгүй шинээр байгуулсан үрийн сангаар дамжуулан дотоодын үр үйлдвэрлэлийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлээ.

Хот суурин газрын ядуу өрхүүдэд өрхийн тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх нь ядуурлыг бууруулах үр дүнтэй хэрэгсэл болох нь нотлогдож байна. Улаанбаатар хотын гэр хорооллоос дөрвөн гудамжийг загвар болгон сонгоод 61 өрхөд ногоо тариулж туршлаа. Ингэснээр өрхийн хүнсний ногооны хэрэглээ нэмэгдэж, илүү бүтээгдэхүүнээ борлуулснаар орлогоо нэмж чадлаа. Төслөөс эдгээр өрхийг худаг, хүлэмж, үр, багаж хэрэгслээр хангаж өгсөн байна. Түүнчлэн 1000 гаруй хүнийг (70 хувь нь эмэгтэй) хүнсний ногоо тариалах, хэрэглэх (хоол хийх, боловсруулах) сургалтад хамруулжээ.

Тус төсөл 2016 онд Хүнсний ногоо тариалагчдын хоёр төвийг шинээр байгуулж, тариаланчдад зөвлөгөө, дэмжлэг үзүүллээ. Эдгээр төвүүд тариаланчдад зөвлөгөө мэдээлэл өгөөд зогсохгүй дотоодод үйлдвэрлэсэн үр, бордоогоор хангадаг.

Түүнчлэн төслөөс байцааны үрслэг үржүүлэх 9 цэг шинээр байгуулах, 1000 тонн байцаа хадгалах зоорь барих, шинэчлэн засварлахад дэмжлэг үзүүлжээ. Тариаланчид эдгээр зооринд өвлийн улиралд байцаагаа хадгалж байна.

# АМЖИЛТЫН ТҮҮХЭЭС

## ХАШААНААС ЦЭЦЭГЛЭСЭН БОЛОМЖУУД



Дэжид хүүхдүүдийн хамт ургацаа хурааж буй нь.  
© Б. Батболд / Монгол ногоо төсөл

Амьдрал дандаа хялбар байддаггүй. Зарим хүн илүү их бэрхшээлтэй тулгардаг. Тэдний нэг бол гурван хүүхдийн ээж Дэжид юм. Ханийг нь Тодгэрэл хэмээнэ. Тодгэрэлийнх Улаанбаатар хотоос 40 км зайтай Налайх дүүрэгт амьдардаг.

Гурван хүүхдийн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй учраас Дэжид тэднийгээ асарч гэртээ суудаг

байв. Нөхөр Тодгэрэл нь мөн л тогтмол ажилгүй тул цагийн эсвэл улирлын чанартай бага хөлстэй ажил хийж амьжиргаагаа залгуулсаар иржээ. Хэдий ийм хүнд нөхцөлд амьдардаг ч Дэжид амьжиргаагаа сайжруулах итгэл найдвараа хэзээ ч алдаагүй юм.

Тиймээс ч тэрээр долоон жилийн өмнөөс хашаандаа төмс, хүнсний ногоо тариалж эхэлжээ. Ингэснээр ургацаа хүнсэндээ хэрэглээд илүү гарсныг нь борлуулж нэмэлт орлого олох болов. Эхний жил 10 кг төмс хурааж хүнсэндээ хэрэглэхийн хамт бага зэргийг борлууллаа. Ийнхүү ногоо тарьж орлого олох боломжтойг ойлгов. Удаах жил нь шар манжин, лууван, байцаа, навчит ногоо тариалж ургацынхаа нэр төрлийг нэмэгдүүлснээр 200,000-300,000 төгрөгийн ашиг олж чадсан юм. Хэдийгээр энэхүү ашгийн хэмжээ тийм их байгаагүй ч илүү ашигтай ажиллах боломжтойг ухаарав.

Тодгэрэлийн гэр бүл 2016 онд “Монгол ногоо” төслөөс зохион байгуулсан сургалтанд хамрагдсанаар 4x8 хэмжээтэй дуслын усалгааны систем бүхий хүлэмж, гүзээлзгэний 200 ширхэг үрсэлгээний дэмжлэг авав. Сургалтаас олж



Шинэ ургацын амт. Монгол ногоо хөтөлбөрийн үр шимийг хүртэгсдийн нэг Л. Тодгэрэлийнх.  
© Б. Батболд / Монгол ногоо төсөл

авсан мэдлэгээ ашиглан гүээлзгэний үрсэлгээ ургуулж сурчээ. Намар нь гүээлзгэний 300 ширхэг суулгац бэлтгэлээ. Нэг ширхэг суулгацыг 5,000 төгрөгөөр хөршүүдтэй борлуулснаар нийт 1,5 сая төгрөгийн ашиг олов.

Мөн төслийн хүрээнд хүнсний ногооны хатаалтын технологийн сургалтанд хамрагдав. Ингэснээр ногоо хатааж сурч, өрхийн хэрэгцээнээс илүү гарсан ургацаа хатааж зарах боломжтой болсон юм. Хатаасан ногоог савлаад борлуулахад нэмүү өртөг бүхий үнэ нь 2-3 дахин нэмэгдэх боломжтой. Тэд ийнхүү хатаасан ногооноосоо нийт 2 сая төгрөгийн ашиг олохоор байна.

Төслийн хүрээнд онол, дадлагын сургалтуудад хамрагдаж, ногоо тарьж байгаа өрх, аж ахуйн нэгжийн талбайгаагаас туршлага судлах аялалд оролцсон нь миний хувьд ногоо тарьж ургуулах хүслийг улам нэмж, илүү их ажиллах эрч хүч, сонирхолтой болсон. Энэ жил шинэ таримал тарьж, хүнсний ногоогоо хатаах шинэ технологийг сурсан нь манай өрхийн орлого нэмэгдэж, амтлаг жимс ногоо хүүхдүүддээ өгөөд зогсохгүй цаашид илүү их боломж байгааг олж харсан” гэж тэрээр ярилаа.



## Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС)

# Хөтөлбөрийн онцлох үр дүн

ШХА мэргэжлийн боловсролын сургууль төгсөгчид, мэргэжилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч, Монголын мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг бэхжүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлдэг томоохон хандивлагч хэвээр байна.

2016 онд харилцан уялдаа бүхий хоёр төслийн шинэ үе шатыг эхлүүлсний нэг нь Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (ЗХЭДТ) буюу 2012 онд эхлүүлсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын төслийн үргэлжлэл, нөгөө нь Монгол дахь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж байгаа Мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх төслийн хоёрдугаар үе шат байв.

## **Ажилгүй иргэд болон залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх нь**

Шинээр эхэлсэн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл нь ажил хайж буй залуусын хөдөлмөр эрхлэх чадамжийг дээшлүүлэх зорилготой. Тус төсөл ажил хайгчид ба ажил олгогчдын хооронд зуучлах замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах, залуусын ажил эрхлэлтэд ээлтэй бодлогын орчин бий болгон хөгжүүлэх, тэдний хувиараа хөдөлмөр эрхлэлт, ирээдүйтэй шинэлэг гарааны бизнесүүдийг дэмжихэд голлон анхаардаг.

Өмнөх болон энэ жилийн мөшгих судалгаагаар зорилтот сургуулиудын эрэлтэд чиглэсэн арга болон сургалтын чанарыг сайжруулах аргууд үр дүнтэй болох нь харагдлаа. Баруун бүсэд мэргэжлийн боловсролын сургууль төгсөгчдийн ажил эрхлэлт 53 хувьд хүрсний зэрэгцээ өнгөрсөн хоёр жилд зорилтот зургаан төрлийн мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 63-аас 66 хувь болж нэмэгдсэн. Мөн эмэгтэй төгсөгчдийн хувь 42-оос 59 болж өсчээ.

Мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх төсөл (МУЧХ)-ийн нэгдүгээр үе шат 2016 оны гуравдугаар сард дуусгавар боллоо. Ингэснээр төсөлд хамрагдсан мэргэжлийн боловсролын сургуулиуд 2016-2017 оны хичээлийн жилд орчин үеийн тоног төхөөрөмж ашиглан богино хугацааны ур чадвар олгох чанартай сургалт явуулаад зогсохгүй компаниудын ажиллах хүчний эрэлт хэрэгцээг хангаж байна.

## **Залууст ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлсэн нь**

Монголд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ дутагдалтай байгаагаас залуус мэргэжлээ сонгох шийдвэр гаргахад

бэрхшээлтэй байна. МУЧХ төслийн дэмжлэгээр мэргэжлийн боловсролын сургалтын төвүүд, орон нутгийн хөдөлмөрийн хэлтсүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгөх зорилготой 22 төвийг байгуулан ажиллуулж залуус, ажилгүйчүүдийн хэрэгцээнд тохирсон үйлчилгээ үзүүлж байна.

Зөвлөгөө авсан үйлчлүүлэгчдийн 77 хувь (үүнээс 53 хувь нь эмэгтэй) нь ажил мэргэжлийн шийдвэрээ амжилттай гаргахад эдгээр төвүүдээс авсан мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ их тус болсон гэж хариулжээ. Түүнчлэн МУЧХ төслөөс боловсруулсан Монголын анхны гар утасны аппликейшн болох "Mergejil.mn"-г нийт 17,340 хүн ашигласан байна. Энэхүү аппликейшн 48 ажил мэргэжлийн тухай мэдээлэл агуулсан бөгөөд сургууль, мэргэжлээ сонгоход нь залууст туслах зорилготой юм.

## **Мэргэжлийн боловсролын сургалтыг хувийн хэвшилтэй холбох нь**

Мөн тус төслөөс хувийн хэвшил ба мэргэжлийн сургуулиудын хамтын ажиллагааг илүү сайн уялдуулахад туслаж байна. Төслийн түнш компаниудын дунд явуулсан судалгаагаар мэргэжлийн боловсролын зорилтот сургуулиудын төгсөгчдийн чанар дээшилж байгааг нотолсон бөгөөд тэдний 85 хувь нь төгсөгчдийн чанар сайн ба маш сайн байна гэж үнэлжээ. Одоогийн байдлаар орон нутгийн компаниуд ба техник, мэргэжлийн зорилтот сургуулиудын хооронд хамтын ажиллагааны 28 гэрээ байгуулж, туршилтын долоон мэргэжлээр дадлагажуулах сургалт явуулж байна.

Мэргэжлийн боловсролын сургуулиуд дахь хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байна. Монгол, Германы хувийн хэвшлийн гол төлөөлөл болох Оюу Толгой болон Festo Didactics



### МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ




**49%**

МСҮТ төгсөгчдийн ажил эрхлэлт, улсын дундаж



**53%**

Баруун бүсэд мэргэжлийн боловсролын сургууль төгсөгчдийн ажил эрхлэлт



**66%**

Зорилтот зургаан төрлийн мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт



**59%**

Эмэгтэй төгсөгчдийн хувь 42-59 хувь болж өсчээ

### БОГИНО ХУГАЦААНЫ УР ЧАДВАР ОЛГОХ СУРГАЛТУУД

Гол төлөв мэргэжилгүй, 40-өөс дээш насны ажилгүй иргэдийн дунд эрэлт хэрэгцээтэй байдаг.



**616**

ЭР



**192**

ЭМ



**56%**

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт  
78% - ЭР      22% - ЭМ

ХХК хамтран Даланзад, Дархан, Дорнодын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг шинэчлэн “Чадамжийн төвүүд” болгон хөгжүүлэх тухай хамтын ажиллагааны гэрээг Хөдөлмөрийн яамтай байгууллаа. Эдгээр төвүүд нь олон улсын стандартын дагуу салбарын эрэлт хэрэгцээнд тулгуурлан сурагчдад техник мэргэжлийн боловсрол олгохын зэрэгцээ бусад сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн багш нар, ажилгүй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бусад ажилчдад зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтууд явуулах юм.

#### **Богино хугацааны сургалтаар мэргэжлийн ур чадвар олгох нь**

МУЧХ төсөл баруун бүсийн аймгуудын мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх, сонгогдсон чиглэлээр богино хугацааны ур чадвар олгох сургалт явуулахад анхаарч ажиллалаа. Төслөөс баруун ба өмнөд бүсийн аймгууд, Улаанбаатар, Дархан хотын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг сонгож авсан.

Богино хугацааны ур чадвар олгох сургалтууд гол төлөв мэргэжилгүй, 40-өөс дээш насны ажилгүй иргэдийн дунд эрэлт хэрэгцээтэй байдаг. Зорилтот сургуулиудад явуулж буй эдгээр сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 56 хувь (22 хувь нь эмэгтэй) байсан бөгөөд сургалтаа төгсөөд гурван сарын дотор цалинтай ажилд орсон төгсөгчид 25 хувийг эзлэж байлаа.

Уг төслөөс мөн механик, барилгын чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн туршилтын төвүүдэд эдгээр мэргэжлийн 115 багшийг дахин сургажээ. Түүнчлэн эдгээр сургалтыг хэрэгжүүлж буй зорилтот сургуулиудад 950,000 еврогийн өртөг бүхий багаж, тоног төхөөрөмж олгосон байна.

#### **Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих нь**

Хот суурин газарт жижиг бизнес эхлэн эрхлэгч нарт бизнесийн зөвлөгөө өгөх, зааж сургах, хөнгөлөлттэй зээл олгох үйлчилгээ үзүүлдэг Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих (ЖДҮ) төслийн дэмжлэгийн үр дүнд төслөөр үйлчлүүлэгч 89 ЖДҮ бизнесийн үйл ажиллагаа,

удирдлагын ур чадвараа сайжрууллаа. Эдгээрийн үр дүн 1000 ажлын байр шинээр бий болгожээ.

#### **Залуучуудын амьдрах ухааныг дээшлүүлэх нь**

Залуусын амьдрах ухааны боловсролыг институтжүүлж, тэдний ажил эрхлэх, амьдрах чадварыг дээшлүүлэх зорилготой НҮБ-ын Хүн амын сангийн Залуучуудын хөгжлийн төсөлд ШХА-аас дэмжлэг үзүүлж байна. Төслөөс улсын хэмжээгээр залуучуудын хөгжлийн 16 төв байгуулж, 25,000 гаруй залууст (58.4 хувь нь эмэгтэй) үйлчилсэн нь өмнөх жилийн үзүүлэлтээс хоёр дахин нэмэгдсэн байна. Шинээр байгуулагдсан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн үндэсний газар эдгээр хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг 2017 оноос эхлэн хариуцаж, тогтвортой ажиллагааг ханган ажиллана.

#### **Тогтвортой хөгжлийн төлөөх боловсролыг албан боловсролын салбарт нэвтрүүлэх нь**

ШХА-ийн Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) төсөл Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран ТХБ-ын үзэл баримтлалыг албан боловсролын системд нэвтрүүлэхийн зэрэгцээ ногоон хөгжлийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж байна. ТХБ-д тулгуурлан ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн цөм хөтөлбөрийг шинэчлсэн нь улсын болон хувийн хэвшлийн 768 сургуульд бүрэн хэрэгжиж, 2016 оны хичээлийн жилээс улсын хэмжээгээр нийт 19,249 багш (73.4 хувь нь эмэгтэй), 147,031 сурагчдад (49.3 хувь нь эмэгтэй) хүрнэ. Энэ нь боловсролын салбарын шинэчлэлийг хэрэгжүүлэх үндэс суурь болоод зогсохгүй сурах бичгийг засварлах, хичээл дээр хийх дасгал зэрэг сургалтын бүхий л талыг хамарч байгаа юм.

Түүнчлэн, ТХБ-ын төслийн дэмжлэгтэйгээр Ногоон хөгжлийн бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж 2016 оны нэгдүгээр сард Засгийн газрын тогтоолоор батлууллаа. Энэхүү төлөвлөгөө нь Монголд ногоон, тогтвортой хөгжил бий болгоход зайлшгүй шаардагатай хууль эрх зүйн орчинг бүрдүүлж байна.



# АМЖИЛТЫН ТҮҮХЭЭС

## СҮҮНИЙ ФЕРМИЙН ЗАЛУУ ЭЗЭН



Я. Чагнаадорж, Баясгалан нар Залуучуудын гарааны бизнес дэмжих хөтөлбөрт шалгарч, шагналаараа тарагны үйлдвэрлэлээ өргөжүүлжээ.  
© ШХА / Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл

Я.Чагнаадорж нас дөнгөж хорь гарч яваа ч амьдралд хөлөө олох гэж нэлээдгүй сорилт давжээ. Их сургуульд нягтлангийн мэргэжлээр суралцаж байгаад төлбөрийн боломжгүйгээс сургуулиа орхихдоо юу хийж яаж амьдрах учраа олохгүй явсан үе саяхан.

Хөдөө төрж өссөн, малчны хүүхэд болохоор заавал нягтлан бодогч болох гэж зүтгэсэнгүй. Харин сургуульд сурах богинохон хугацаандаа ирээдүйн эхнэр Баясгалантайгаа танилцсан аж.

Эрхэлсэн ажилгүй дэмий суухаар малчин аав ээждээ тус дэм болохоор Я.Чагнаадорж нэг л өдөр нутаг буцлаа. Ингээд гэртээ мал маллаж байхдаа өөрийн гэсэн бизнес эхлүүлэхээр шийджээ. Хэдэн жилийн өмнөх зуданд тэднийх олон тооны мал алдсан юм. Тиймээс зуд турханд амархан өртдөг уламжлалт нүүдлийн ахуйгаас татгалзаж суурин аж ахуй эрхлэх санаа сэдэн, саалийн зургаан үнээтэй сүүний ферм байгуулжээ.

Удалгүй, Я.Чагнаадорж, Баясгалан хоёр өрх тусгаарлав. Тэд өглөөнөөс үдэш болтол шаргуу ажиллаад ч ашиг орлого нь өөрсдийн өдөр

тутмын хэрэгцээнээс (сард 800,000 төгрөг) илүү гарсангүй. Өвөлдөө нэг үнээнээс ердөө гурван литр сүү саана. Зундаа найман литрийг саах боловч сүүний нийлүүлэлт нэмэгдсэнээс олигтой борлуулж чадсангүй.

Ийнхүү учраа олохгүй, эхлүүлсэн ажлаа унагаачихгүй хэмээн зүтгэж явтал нэгэн өдөр түүнийг аймгийн Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төвөөс дууджээ.

Баянхонгор Политехникийн коллежийн дэргэдэх ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төвөөс аймгийнхаа ажилгүй болон ажил мэргэжлийн дэмжлэг зөвлөгөө хэрэгтэй залууст хандсан олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж.

Тус төвийн зөвлөх А. Энх-Амгалангийн хувьд нэлээд олон залуустай ярилцсан жирийн нэг өдөр байсан ч Я.Чагнаадоржийн хувьд амьдралд нь эргэлт авчирсан онцгой өдөр болсон юм.

А.Энх-Амгалан залуу гэр бүлд хандаж тус коллежийн дэргэд мал аж ахуй, газар тариалангийн хосолсон фермерийн мэргэжил дээшлүүлэх нэг жилийн түргэвчилсэн сургалт эхэлж байгааг хэлээд тэдэнд суралцахыг зөвлөсөн аж.

Ийнхүү Я.Чагнаадорж коллежид сурснаар фермерийн аж ахуйн талаар чамгүй мэдлэг хуримтлуулж, улмаар сурч мэдсэнээ даруй фермертээ ашиглах болжээ.

Эдүгээ, тэднийх бүл нэмж хүүтэй болсон. Эхнэрийнхээ хамт өргөжин тэлж буй ферм дээрээ тун завгүй ажиллаж байна. Саалийн хорин үнээтэй болж, дарш, багсармал тэжээлийн ачаар сүүний гарц ч даруй 50 хувиар өсчээ. Ажлаа дийлэхээ больсон залуу фермер хоёр туслах ажилчинтай хамтарч байна.



Улмаар, сүүгээ өөрсдөө боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хөлдөөсөн тараг зах зээлд нийлүүлэх болов. Бүтээгдэхүүний дээжээс амссан коллежийн багш нь “Чагнаагийн үйлдвэрлэсэн ‘Бабуулай’ тараг миний ажлын үр дүн, надад өгсөн өндөр шагнал мэт санагдсан. Их сайхан амттай тараг болсон байна лээ” хэмээн үнэлжээ.

Мал аж ахуйд суурилсан бизнесийн ашиг нэмэгдэж, залуу гэр бүлийн сарын орлого нь 2.8 сая төгрөг болжээ. Энэ тоо зуны улиралд бүр ч өсөх хандлагатай байна.

Тэдний амжилт үүгээр зогссонгүй. 2016 оны 10-р сард Баянхонгор аймгийн Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт шалгарч, 10 сая төгрөгийн тэтгэлэг хүртсэн нь түүний хувьд хамгийн том шагнал байлаа.

Тэтгэлгээ тарагны бизнесээ өргөжүүлэхэд нэн шаардлагатай сав суулга, хөлдөөгч зэрэг тоног төхөөрөмж авахад зориулжээ.

Я.Чагнаадорж цаашид үйлдвэрлэлээ өргөжүүлэн хуурай сүү, зайрмаг зэрэг олон төрлийн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж орон нутгийнхаа төдийгүй Улаанбаатарын зах зээлд нийлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

“Сонирхлоо үргэлж дагаж, санасандаа тууштай байж, хэзээ ч бууж өгөлгүй, байнга суралцаж, шаргуу ажиллах л хэрэгтэй” гэж тэрээр гарааны бизнесээ эхэлж буй үе тэнгийнхээ залууст зөвлөж байна.

Ажилгүй болон ажил идэвхтэй хайж буй залууст ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, мөн залуучуудын гарааны бизнесийг дэмжих замаар залуучуудын ажил эрхлэх боломжийг дээшлүүлэх зорилготой ШХА-ийн энэхүү цогц хөтөлбөр нь Я.Чагнаадоржийн нэгэн адил олон залууст амьдралд хөлөө олж, ажил хөдөлмөрийн мөр хөөхөд нь дэмжлэг үзүүлж байна.



## Төрийн захиргааны шинэтгэл, нутгийн удирдлага ба иргэдийн оролцоо

Сүүлийн жилүүдэд иргэд төр засагтаа дуу хоолойгоо хүргэх, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь нэмэгдэж байгаа. Үүний нэг төд жишээ бол агаар бохирдлыг бууруулах тодорхой арга хэмжээ авахыг шаардаж иргэд нэгдэн жагссан жагсаал юм. © Д. Давааням

# Хөтөлбөрийн онцлох үр дүн

Монгол улсад засаглалын салбарт Швейцариаас үзүүлж буй дэмжлэг нь орон нутгийн захиргааг үр нөлөөтэй, өгөөжтэй, шударга ажиллагаатай болгож иргэдийн сэтгэл ханамжтай байдлыг дээшлүүлэх, тэдний жинхэнэ төлөөлөл бүхий үр нөлөөтэй иргэний нийгмийн байгууллагууд бий болгоход чиглэдэг.

## **Иргэдийн төлөөлөгчдийн хурлын чадавхыг бэхжүүлэх нь**

Монголд ардчиллын эрүүл практикийг орон нутгийн түвшинд тогтооход иргэдийн төлөөлөгчдийн хурлуудын үр нөлөөтэй байдал шийдвэрлэх үүрэгтэй. Тиймээс НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлсэн Нутгийн өөрөө удирдлагын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх нь төслөөс хурлын төлөөлөгчдийг сургаж, чадавхжуулахад анхаарч ажиллалаа. Энэ нь орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлууд ард иргэдийг төлөөлж орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих хуулиар олгогдсон үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг болсон юм.

Нийт 8000 гаруй төлөөлөгчийг тэдний үндсэн үүргийн талаарх сургалтад хамруулж, илүү хариуцлагатай ажиллаж, орон нутгийн захиргаанд тавих хяналтаа сайжруулах боломж олголоо.

Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлууд дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн адил тэгш төлөөллийг хөхиүлэн дэмжих нь тус төслийн салшгүй нэг хэсэг бөгөөд орон нутгийн хуралд сонгогдсон нийт 1518 эмэгтэй төлөөлөгчийн 75 хувийн манлайлах чадварыг дээшлүүлээ.

Бүх шатны 361 хурлын байгууллагыг холбосон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэгдсэн вэбсайт ([www.khural.mn](http://www.khural.mn)) бүрэн ажиллаж эхэлсэн бөгөөд улс төрчид, иргэдийн мэдээлэл, туршлага солилцох, харилцан суралцах талбар болоод байна.

## **Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь**

Олон нийтийн хэлэлцүүлгийн чанар, иргэний болосролын кампанит ажлууд, тэтгэлэгт хөтөлбөр зэргийг хэрэгжүүлсний үр дүнд иргэд орон нутгийн ажил хэрэгт оролцох нь түгээмэл практик болоод байна. Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн нийт 361 хурлын 15 хувь нь алслагдмал газарт буй малчдад хөдөлгөөнт иргэний танхим ашиглан хүрч тэднийг шийдвэр

гаргалтад татан оролцуулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлээд байна.

Орон нутгийн захиргаад иргэдийнхээ санал болгосон тэргүүлэх чиглэлүүдээр хөрөнгө оруулалт хийхэд зориулж олгодог Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гуудын хэрэгжилтэд ШХА дэмжлэг үзүүллээ. Эдүгээ орон нутгийн захиргаад ОНХС-ийн төслийн бүхий л мөчлөгийг төсвийн болон бараа, үйлчилгээ худалдан авалтын хуулиудад нийцүүлэн удирдах чадвартай болоод байна.

ОНХС-ийн иргэдээс санал авах маягт, хяналтын шалгах хуудас, хөрөнгө оруулалтын мэдээллийн сан, жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээ зэргийг боловсронгуй болгон хэрэглэх замаар орон нутгийн захиргаад хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналтын чадавхыг бэхжүүлээ. ШХА-ийн дэмжлэгийн үр дүнд орон нутгийн хурлууд хяналтын үүргээ илүү хүчтэй хэрэгжүүлдэг, хариуцлага сайн тооцдог болсон байна.

## **Төвлөрлийг сааруулах бодлого батлагдлаа**

Төвлөрлийг сааруулах шинэтгэлийн талаар Засгийн газраас боловсруулсан анхны төрийн бодлогын баримт бичиг 2016 оны зургадугаар сард батлагдсан нь орон нутгийн засаг захиргааны чиг үүргийг илүү тодорхой болгож, санхүүжилтыг тэнцвэртэй хуваарилахад чиглэсэн байна. ШХА-ийн Төвлөрлийг сааруулах, засаглалыг дэмжих хөтөлбөрөөс Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэхүү төвлөрлийг сааруулах стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, төвлөрлийг сааруулах, ардчилах чиглэлээр Швейцарь улсын хуримтлуулсан мэдлэг, туршлагуудаас хуваалцлаа.

## **Эрчим хүч хэмнэх, сайн засаглалыг бэхжүүлэх загварыг танилцууллаа**

Орон нутгийн хөгжлийн сан, Эрчим хүчний үр ашиг (ЭХҮА) төслийн дундын санг үр дүнтэй ашигласны ачаар нийт 13 цэцэрлэг, сургууль, эмнэлгийн барилгад дулааны алдагдлыг

бууруулах техникийн шинэчлэл засвар хийсэн. Дулаан техникийн засвар хийсэн барилгууд өвлийн улиралд дотоод хэм нь тогтмол 21°C байхад засварлаагүй барилгуудынх 10°C байна. Засварласан барилгуудын жилийн дулаанаас үүсдэг агаарын бохирдол 57 хувиар буюу 99 тонноор буурчээ.

ЭХҮА төслөөс хуримтлуулсан мэдлэг туршлага, сургалтуудын үр дүн Ховд, Завхан аймгийн Үндэсний их сургуульд Төрийн захиргааны удирдлагын зэрэг олгох сургалт нээж, орон нутгийн ажилтнуудад зориулсан төрийн санхүүгийн удирдлага, худалдан авалтын сургалтыг институтжуулжээ.

#### **Орон нутгийн захиргааны үйл ажиллагаа, хариуцлагатай байдал сайжирлаа**

Хотын засаглалын төслөөс иргэдэд нэн тэргүүнд шаардлагатай байгаа үйлчилгээний

хүртээмжийг дээшлүүлэх, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийн амьдралыг сайжруулж байна. Төслөөс төв, орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагааг сайжруулах, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын төрийн хэрэгт оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар хотын захын болон гэр хорооллын өрхүүдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүллээ. Улаанбаатарын гэр хорооллын 2800 гаруй өрхийг (түүний дотор бага орлоготой 396, ганц бие өрхийн тэргүүнтэй 320, эмэгтэй өрхийн тэргүүнтэй 280, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй 230 өрх) төлөөлсөн 12 хорооны (нийт 150 хорооноос) иргэд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн 12 үйлчилгээг хамтран тодорхойлоод байна.



Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлуудыг газрын зураглал дээр буулгах ажлын үеэр Налайх дүүргийн 3 дугаар хорооны хэсгийн ахлагч нар өөрийн хэсгийн хил заагийг зурж байгаа нь.  
© Билли Макрае / Гэр хорооллын иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв

#### **Иргэний нийгмийн байгууллагуудын чадавх, нийгмийн эгэх хариуцлагыг дээшлүүллээ**

Засаглалын чиглэлээр хэрэгжиж буй ШХА-ийн хэд хэдэн төсөл орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын (ИНБ-ууд) чадавхыг бэхжүүлж тэднийг төрийн байгууллагын хариуцлагатай байдалд хяналт тавьдаг болоход нь дэмжлэг үзүүлж байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх төсөл орон нутгийн ТББ-уудад сургалт, техникийн туслалцаа үзүүлж төслийн хэрэгжилтэд татан оролцуулснаар орон нутгийн захиргааны үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чадвартай боллоо. Эдгээр ТББ-аас орон нутгийн хурлын иргэдийн өмнө хүлээх

үүрэг, тэргүүн туршлагын эмхэтгэл, ёс зүйн дүрэм, уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох журам, орон нутгийн хурлын хяналт тавих журам зэрэг чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулаад байна.

Мөн Монголд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь төслөөс нийгмийн хариуцлагын хэрэгслүүдийн хүртээмжийг сайжруулах замаар орон нутгийн ТББ-уудад дэмжлэг үзүүлж байна. Дэлхийн Банк, ШХА-ийн хамтран хэрэгжүүлж буй энэ төсөл улсын салбарт нийгмийн эгэх хариуцлагын тухай ойлголтыг гүн бат суулгаж өгснөөр засаглалыг бэхжүүлэх, улсын төсөв, хөрөнгийн удирдлагыг сайжруулах үр дүнтэй арга болж байна.

# АМЖИЛТЫН ТҮҮХЭЭС

## АМЬДРАЛД ХӨЛ НИЙЛҮҮЛСЭН БОЛОМЖ



Батнасангийн Ууганцэцэг  
эрчим хүчний үр ашиг  
сайжруулах төслийн хүрээнд  
засварлаж буй барилга дээр  
дадлга хийж ур чадвараа  
сайжруулсан.  
© ШХА

Би 1996 онд Ховд аймгийн Булган суманд төрсөн. Аав ээж маань машины ослоор бурхан болоход би хоёрхон настай үлдсэн юм.

Тэгээд л эмээ өвөө дээр очсон. Гэвч тэд маань намайг долоон настай байхад өөд болсон. Ингээд дөрөвдүгээр ангид ортлоо авга ахындаа амьдраад, дараагийн хоёр жил ээжийнхээ хамаатныд байсан юм.

Тэндээсээ Улаанбаатарт амьдардаг бас нэг авга ахындаа ирж 11-р ангиа төгсөж билээ. Хан-уул дүүргийн 60-р сургуулийг дүүргээд Ховд аймагтаа эргэж очоод Политехникийн Коллежид барилгын засал чимэглэлийн курст суралцлаа. Тэнд нэг жил сурахдаа дотуур байранд амьдарсан.

Хүүхэд нас минь үхэл хагацал, зовлон дундуур туучиж өнгөрсөн. Харин коллежид суралцаж эхлэхдээ ирээдүй гарт минь байгааг ойлгосон юм. Бусдад ч мөн ингэж хэлж урамшуулахыг би хичээж байв.

Сургуулиа төгсөөд сайн ажилтай болохын тулд бүх боломжийг ашиглан, олон оюутнаас илүү хичээнгүйлэн суралцсан билээ.

Би ямар ч зүйлд чин сэтгэлээсээ чармайж ажилладаг. Коллежийн 2015 оны спортын тэмцээнд өрсөлдөөд охидын 100, 200, 800 метрийн гүйлт болон уртын харайлтын төрлөөс алтан медаль авав. Уг нь 400 метрт гүйх байсан юм. Гэтэл багш маань “нэг хүн олон төрлөөр өрсөлдөх зохисгүй” гээд өөр оюутныг өрсөлдүүлсэн ч тэр түрүүлж чадаагүй. Тэгэхэд манай ангийнхан “хэрвээ чи орсон бол түрүүлээд таван алтан медаль авах байсан даа” гэж хэлж билээ. Бусад хүмүүс намайг ингэж үнэлж байгааг сонсоод би баярлаж байв.

Коллежийн дадлагын ажлаа Жаргалант сумын 2-р сургуулийн барилгын ажил дээр хийх хүсэл төрж байсан л даа. Тэнд дулааны алдагдлыг бууруулах засварын ажилд засал чимэглэлийн ажилд гар бие оролцмоор санаагдаад. Тэгээд “Эрчим хүчний үр ашиг” төсөлд энэ хүсэлтээ гаргасан. Тэд ч намайг дэмжсэнээр өмнө минь том үүд хаалгыг нээж өгсөн юм даа. Миний ижил олон залууд ажлын дадлага туршлагатай болох, төсөл дуусахад тухайн мэргэжлээрээ үргэлжлүүлэн ажиллах боломжийг уг төслийнхэн олгосон.

“Дулааны алдагдлыг бууруулж, эрчим хүч хэмэх технологиор барилгын засварыг хийхэд байшин барилга харьцангуй дулаан болдог. Гэхдээ тухайн ажлыг чанарын зохих түвшинд хийж байж л тийм үр дүнд хүрнэ” гэж төслийн зөвлөх инженер бидэнд хэлж байсан. Ийнхүү Ховд аймгийнхны анхаарлын төвд байсан барилга дээр дадлага хийснээрээ коллежид сурсан мэдлэг чадвараа би улам батжуулсан юм.

Дадлагаа дуусаад өнгөрсөн зургадугаар сард коллежоо төгслөө. Удаа ч үгүй байтал төслийн хамтарсан санхүүжилтээр нутгийн барилга угсралтын компанид дадлага хийж байсан долоон залуу ажилтнаас тавыг нь сонгоход би багтлаа.

Эмнэлэгийн барилгын засварын 2.5 сарын хугацаатай төсөлд ажиллуулахаар ийнхүү

манай багийг бүрдүүлсэн юм. Яг энэ үеэр бас нэг барилгын компани Дарви суманд 164m<sup>2</sup> барилгын засал чимэглэл хийлгэхээр манай даргын зөвшөөрлөөр бидэнтэй давхар гэрээ байгуулав. Ингэснээр багийнханы маань ажлын чанар олонд танигдаж эхэлсэн дээ.



Инженерийн хяналтгүйгээр ажлаа гэрээт хугацаанаас өмнө төсөв мөнгөнд нь багтааж чанартай гүйцэтгэхэд компаний захирал нь бидэнд баяр талархалаа илэрхийлж байлаа. Одоо манай баг өөр нэг төсөл дээр, 1400m<sup>2</sup> барилгын засал чимэглэл дээр ажиллаж байна. Коллежоос болон дадлага ажлаас сурсан мэдлэг, туршлагаа бид бусад ажилчидтайгаа хуваалцдаг. Манай баг саяхан Монголын барилгачдад зориулсан томоохон арга хэмжээнд урилгаар оролцоход би их баярласан. Одоо би санхүүгийн хувьд биеэ даасан. Өмнө нь автобусны мөнгө хүнээс зээлдэг байв. Харин одоо өөрөө бусдад мөнгө зээлүүлдэг. Би банкинд данс нээгээд ирээдүйн сургалтын төлбөрөө хадгалж байгаа. Цэргийн харилцаа холбооны ажилтан болох багын мөрөөдөл маань биелэх ч юм билүү.

Хэдийгээр хар багаасаа хүнд хэцүүг туулсан ч би амьдралын төлөө тууштай тэмцэхээр шийдсэн юм. Тэгэхийн тулд боломж нэг бүрийг зөв ашиглаж ирсэн. Тэдгээрээс төслийн хүрээнд дадлага ажил хийхээр болсон нь миний хувьд хамгийн том боломж байлаа.

Одоо намайг ямар түвшинд хүрсэнийг хар л даа. Би амьдралд өөрийн гэсэн байр суурьтай, банкинд хадгаламжтай, хамгийн чухал нь бусдын хүндэтгэл хүлээсэн залуу ажилчин болоод байна.



## Тогтвортой бичил уурхай төсөл



# Тогтвортой бичил уурхай төслийн үр дүн:

Бичил уурхайг албажуулах үйл явцын үр шимийг бичил уурхайчид хүртэж байна. Тэд орон нутагтаа хүлээн зөвшөөрөгдөх нь нэмэгдсэн, төрөөс үзүүлэх үйлчилгээ сайжирсан зэргээр дуу хоолойгоо илүү үр нөлөөтэй хүргэж байгаатай холбоотой юм. ШХА энэ чиглэлээр Засгийн газрыг дэмжин бодлогын болон техникийн туслалцаа үзүүлж байна.

Тогтвортой бичил уурхай төслөөс төрийн байгууллагуудтай хамтран бичил уурхайн үйл ажиллагаа, сургалтуудад хөрөнгө нөөцийг (төсөв санхүү, боловсон хүчин) хамтран зарцуулсан бөгөөд нийт дөрвөн яам, дөрвөн агентлаг, 17 сумын захиргаа хамтарсан бичил уурхайн ажлын хэсэг байгуулжээ.

## **Шударга олборлолтыг баталгаажуулсан алтыг анх удаа экспортлов**

Бичил уурхайчид олборлосон алтаа Монгол Банкнд шууд борлуулах болон Шударга олборлолтын гэрчилгээний системийн дагуу баталгаажуулах замаар орлогоо нэмэгдүүлж байна.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ХАМОДХ ТББ 2016 оны гуравдугаар сард Монголын анхны Экологийн хувьд шударгаар олборлосон алтыг дэлхийн зах зээлд гаргаж экспортлов. Тус ТББ нь Хариуцлагатай уурхайн холбооноос Экологийн хувьд шударгаар олборлосон алтны гэрчилгээг авсан Азийн анхны бичил уурхайн байгууллага болжээ. Үүний тулд тус байгууллага нь эдийн засаг, технологи, байгаль орчны хувьд хариуцлагатай үйл ажиллагаа эрхэлдэгээ нотлох 200 гаруй стандартын шаардлагыг хангасан байна. Ийнхүү анхны 1кг шударга олборлолтын алтыг 6000 ам.долларын дээд үнэ хүргэж экспортложээ. Энэ үйл ажиллагаагаа өргөжүүлэн баталгаажуулсан алтны нийлүүлэлтийн шинэ зах зээлийг эрэлхийлэх боломж бүрдэж байна.

Албажсан бичил уурхайчдын дундаж орлого 2016 онд 12 хувь нэмэгдэж 7.8 сая төгрөгт хүрсэн (2015 онд 7 сая байсан) нь алтны үнэ, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой

байлаа. Мөн Тогтвортой бичил уурхай (ТБУ) төслөөс явуулсан нөлөөллийн үр дүнд бичил уурхайгаас Монгол Банкнд албан ёсоор тушаасан алтны хэмжээ нэмэгджээ.

## **Бичил уурхайчдын байгаль орчны хариуцлага нэмэгдэж байна**

Бичил уурхайчид нөхөн сэргээлтийн энгийн хямд төсөр арга хэрэглэж байгаа нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, экологийн хувьд ээлтэй арга болоод байна. Энэ аргыг ашиглан бичил уурхайгаар ашигласан 200 гаруй га газарт нөхөн сэргээлт хийсний 65 га-г нь орон нутгийн дэмжлэгээр хамтран гүйцэтгэжээ. Төслөөс өнгөрсөн гурван жилд чадавхыг бэхжүүлсний үр дүнд 30-н нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, 19 байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 22 сумын захиргаа баталсан байна.

Монгол улсын Ашигт малтмалын газар (АМГ) 2016 онд бичил уурхайн зориулалтаар 1785 га газарт тусгай зөвшөөрөл олгосон нь 2015 оныхоос 10 хувь өссөн байна. Харин 2015 онд 7325–аар бүртгэгдсэн бичил уурхайчдын тоо 2016 онд 6053 болж буурсан нь батлагдсан газруудын нөөц дууссан, ашиглалтын зардал нэмэгдсэн, орон нутгийн захиргаад төсөв санхүүгийн хүндрэлтэй байсантай холбоотой.

# АМЖИЛТЫН ТҮҮХЭЭС

## САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ БЭРХШЭЭЛИЙГ ҮЛ АЖРАХ АМЬДРАЛ



Мөнгөнцэцэг ажлын талбар дээрээ. © ШХА

Сэлэнгэ аймгийн Мандал сумын жихүүн өглөө... Уурхайчдын хувьд бэрхшээл ойртож буйг зөгнөх мэт. Гадаа -10 хэмээс хүйтэрч газар хөлдөх үед тэдний ажиллах хугацаа хоёр дахин уртасна.

Гэвч нөхцөл байдлаас үл хамааран уурхайчид тэвчээртэй ажилладаг. Тэд тогтсон хэвшлийнхээ дагуу өдөр бүхэн татлага, түгжээгээ сайтар бэхлэн газрын гүн рүү доошилж, алт эрдсийн судал хайн ухна.

Таван хүүхдийн ээж, 42 настай Мөнгөнцэцэг тэдний нэг юм. Бага байхдаа Мөнгөнцэцэг хичээл номондоо гоц сайн бөгөөд гэрэлтэй сайхан ирээдүй, сурлагын өндөр амжилт гаргахыг мөрөөддөг сурагч байв. Гэвч гэр бүлд нь эмгэнэлт явдлууд тохиолдсоноор түүний мөрөөдөл нуран унажээ. Ээж нь бурхан болоход тэр 23 настай үлдэв. Тун удалгүй хойд эцэг нь түүнийг дөрвөн өнчин дүүтэй нь орхин оджээ. “Надад сургуульд сурах цаг, зав, мөнгө байгаагүй” хэмээн Мөнгөнцэцэг өгүүлсэн юм.

Мөнгөнцэцэг нөхөр Энхбаатарын хамт орлого олж, дүү нар болон хүүхдүүдээ тэжээхийн тулд мал хариулах болов. Гэвч 2002 оны зуднаар

дахин нэг гай тохиолдож, тэд бүх малаа зуданд алджээ. Ийнхүү бичил уурхай эрхлэхээс өөр сонголт түүнд үлдсэнгүй.

Тухайн үед бичил уурхай эрхлэх нь хууль бус байсан юм. Түүгээр ч үл барам газрын гүнээс эрдэс баялаг олборлох нь маш олон аюул осол, эрсдэл дагуулж байв. “Зохион байгуулалт сул байсан тул бид алт эрдэс олохын тулд өдөр бүр эрсдэлтэй алхамтай тулгардаг байсан” хэмээн тэрээр дурслаа. Түүнчлэн олсон алтыг нь цагдаа нар хурааж авах эрсдэл ч байсан гэнэ.

Мөнгөнцэцэг болон түүний нөхөр гэр бүлээ тэжээхийн тулд өдөр бүр олон цагаар ажилладаг байв. Амьдрал нь ч бага зэрэг тогтвортой болов. Гэтэл түүнд дахин гэнэтийн эмгэнэлт явдал тохиолдов. Мөнгөнцэцэгийн нэг дүү нь хүүхдийн хамт голд живж нас барлаа. Тэрээр амь үрэгдсэн дүүгийнхээ 5, 6 настай хоёр хүүхдийг үрчилж авав.

Гэсэн ч Мөнгөнцэцэг итгэл алдралгүй гэр бүлийнхээ төлөө хичээнгүйлэн ажилласаар байлаа. Эцэст нь өөрийн мөрөөдөж ирсэн тогтвортой амьдрах боломжийг Тогтвортой бичил уурхай төслийн дэмжлэгтэйгээр бий болгож чадсан юм. Уг төсөл ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдалд анхаарч, бичил уурхайг албажуулах, зохион байгуулалтад оруулах, Монгол дахь бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд болон нөхөрлөлүүдийг бий болгоход чухал хувь нэмэр оруулсан юм.

Төслийн дэмжлэгтэйгээр бичил уурхайчдын дунд гарсан өөрчлөлт хувьсал нь нэгдмэл, хариуцлагатай бичил уурхайчдын бүлгүүд бий болоход нөлөөлжээ. “Нөхөрлөлд нэгдсэнээр мэргэжлийн сургалтад хамрагдах, байгаль орчны нөхөн сэргээлтийг хэрхэн хийх талаар суралцах, бусад уурхайчидтай хамтран ажиллах гэх мэт маш олон боломжийг нээж өгсөн. Нөхөрлөлийн нэг хэсэг байх нь миний хувьд их чухал. Бид нэгдмэл нэг цул болсон

мэт надад санагддаг. Манайхныг дэмжин ажилладаг Тогтвортой бичил уурхай төслийн хамт олонд маш их талархаж байна” хэмээн Билгүүн нөхөрлөлийн гишүүн Мөнгөнцэцэг өгүүлсэн юм.

Бичил уурхай бол хөрөнгө шаарддаг эрсдэлтэй бизнес. Бичил уурхай эрхлэх явцад олборлох үйл ажиллагаа санхүүжилтгүй болох, уурхайн талбар дээрээс алт олдоогүй тохиолдолд өрхийн нөөц орлогыг бүрдүүлэх гэх мэт нэмэлт орлогын эх үүсвэр шаардлагатай болдог. “Бид бичил уурхайгаас сардаа 300,000 орчим төгрөгийн орлого олдог. Гэхдээ сар бүр алт олдоод байдаггүй учраас бидэнд орлогын нэмэлт эх үүсвэр хэрэгтэй” хэмээн Мөнгөнцэцэг хэлсэн юм.

Тэрээр нөхрийн хамтаар төрөөс олгодог сар бүрийн хүүхдийн тэтгэмжийн мөнгийг цуглуулж хүнсний ногоо тарих бизнес эхлүүлжээ. Орон нутгийн төрийн бус байгууллага нь өөр нэгэн хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хүлэмж болон хүнсний ногооны үрээр хангасан байна. “Одоо манай гэр бүлийн орлогын нэг хэсгийг хүнсний ногооны бизнес бүрдүүлж байгаа. Энэ жил бид таван тонн төмс, гурван тонн луван болон бусад ногоо хураан авч байна. Хураасан ногооныхоо нэг хэсгийг зарж, үлдсэнийг нь өвөл хэрэглэхээр хадгална даа. Манайх шиг өнөр өтгөн гэр бүлийг тэжээх хэцүү ч би бүх зүйл сайхан болно гэдэгт үргэлж итгэлтэй байдаг” хэмээн Мөнгөнцэцэг ярилаа.



Энхбаатар, Мөнгөнцэцэг  
нар халуун ам бүлээрээ.  
© ШХА

# 2017 ОНЫ ХЭТИЙН ТӨЛӨВ

ШХА хөтөлбөрийнхөө үр дүнг тогтвортой байлгах, тэргүүн туршлагаадаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор төсөл хөтөлбөрүүдээ нэгтгэн зохион байгуулж эхлээд байна. Хөтөлбөрийн нийт төсөв 2017 онд 16.5 сая шв.франк болж буурна.

2017 онд Хамтын ажиллагааны стратеги шинээр боловсруулах бөгөөд энэ нь өөрчлөгдөн буй орчин нөхцөлд тулгамдсан асуудлуудыг илүү сайн шийдвэрлэхэд чиглэсэн байх ёстой. Шинэ стратеги нь өнөөгийн эдийн засгийн хямралаас цааш ШХА Монгол улсад ямар бодит хувь нэмэр оруулж болохыг тодорхойлох боломжийг олгох юм. Ялангуяа ШХА-аас дунд орлоготой орнуудад болон хот суурин газруудад хэрэгжүүлсэн төслүүд энэхүү Хамтын ажиллагааны стратегид тусгагдах болно.

Мөн Засгийн газар, түнш байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр ирээдүйн зөвлөмжийг боловсруулж үр дүнгийн шинэ хүрээг гаргана. Үүнд ШХА-ийн Дэлхий нийтийн хөтөлбөр, Улс төрийн хэлтэс зэрэг Швейцарийн талын оролцогч талуудтай зөвлөлдөнө. Хамтын ажиллагааны стратегийн төслийн эцсийн хувилбар 2017 оны есдүгээр сард бэлэн болно.

“2020 оны хэтийн төлөв” төслийн хүрээнд дараах шинэ арга барил, санаачлагуудыг туршиж үзэх боломжтой. Үүнд: 1) Хамтын ажиллагааны шинэ чиглэл (ус, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт); 2) Шинэ загвар (хамтарсан санхүүжилтыг нэмэгдүүлж, буцалтгүй

тусламжийг багасгах, Швейцарьт төвтэй тухайлсан техникийн туслалцаа үзүүлэх гэх мэт); 3) Хамтын ажиллагааны шинэ хэлбэр (Монгол, Швейцарь, Хятадын гурван талт хамтын ажиллагаа, ШХА-ийн Дэлхий нийтийн хөтөлбөр гэх мэт).

Энэ хүрээнд “Гэр хорооллын сургууль, цэцэрлэгийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн орчныг сайжруулахад чиглэсэн төлөвлөлт, шийдвэр гаргалтыг сайжруулах”, “Агаарын бохирдлоос хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөний тухай” гэсэн хоёр гэрээ байгуулагдаад байгаа бөгөөд эдгээрийг НҮБ-ын Хүүхдийн сан хэрэгжүүлнэ. Мөн Улаанбаатар зэрэг томоохон хот суурин газарт гамшиг тохиолдох үеийн эрэл хайгуул, авран хамгаалах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр Хятад (Хятадын Газар хөдлөлийн хэрэг эрхлэх газар), Монгол (Онцгой байдлын ерөнхий газар), Швейцарь (Швейцарийн Хүмүүнлэгийн тусламж) хоорондын гурван талт хамтын ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөөд байна.

Эдгээр туршилтын төслүүд Хамтын ажиллагааны шинэ стратеги болон 2020 оноос хойших хамтын ажиллагааны стратеги боловсруулахад тус дөхөмтэй юм. Туршилтын төсөл, санаачлага бүхэн ирээдүйд амжилттай хэрэгжинэ гэдэг баталгаагүй бөгөөд зөвхөн шалгарсан, үр дүнтэй санаачлагууд нь цаашид иж бүрэн, томоохон хэмжээний хөтөлбөр болон өргөжих боломжтой.

# Товчилсон үгсийн жагсаалт

АСЕМ	Ази, Европын чуулга уулзалт
БАХ	Бэлчээр ашиглагчдын хэсэг
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗХЭДТ	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МУЧХ	Мэргэжлийн ур чадварын хөгжил
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УИХ	Улсын Их Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ТБУ	Тогтвортой бичил уурхай төсөл
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ХААХАБ	Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал
ХАМОДХ	Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо
ЭХҮА	Эрчим хүчний үр ашиг төсөл